

## ТАНИЛЦУУЛГА

### *“Дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т “Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянаж шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөл /орон тооны бус/ ажиллана.” гэж, мөн зүйлийн 3-т “Нийгмийн даатгалын байгууллагын болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан Зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална” гэж тус тус заасан.

Хуулийн энэхүү заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 266 дугаар тогтоолоор Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрмийг батлан мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг тус тус хэлэлцэн баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.8-д “Даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл /цаашид "төв зөвлөл" гэх/-ийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл /цаашид "салбар зөвлөл" гэх/-ийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэд тус тус ажиллуулна” гэж, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.12-т “Төв зөвлөл болон салбар зөвлөлийн эрх, үүрэг, хурлын дэг, маргаан шийдвэрлэх үйл явц, ажлын тайлан, хариуцлага зэрэг харилцааг зохицуулсан Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэж тус тус заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, дүрмийн төслийг тус тус боловсруулав.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд жилд дунджаар 480 гаруй өргөдөл, гомдол, хүсэлт ирдэг бөгөөд нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 90 гаруй хувийг шийдвэрлэж ажилладаг. Нийт ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн 60 гаруй хувийг тэтгэврийн асуудлаар ирүүлж байгаа ба хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухай асуудал голлох хувийг эзэлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөл /хуучин нэрээр/ 7 удаа, аймаг, дүүргийн

нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөл нийт 152 удаа тус тус хуралдсан байна.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүнд хуралдсан цагаар нь хөлс олгодог бөгөөд 2022 онд 18.7 сая төгрөгийн цагийн хөлс олгож, 2023 онд 59.4 сая төгрөг, 2024 онд 79.6 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн болно.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**